



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙД Ц.ДАШДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2017.05.25 № 10

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуулгыг тавьж байна.

Манай улсын эдийн засагт хайлуур жоншны салбар томоохон байр суурь эзэлж байсан үе саяхан ч, сүүлийн жилүүдэд энэ салбарын жин нөлөө буурч, байгаль орчинд сөрөг нөлөө нэмэгдсээр, улсын төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх боломж алдагдсаар байгаад дүгнэлт хийх шаардлага тавигдаж байна.

Хайлуур жоншны олборлолтын дүнд төрийн өмчийн болон томоохон компаниудын тоо цөөрч, стандарт бус аргаар жонш олборлогч нөхөрлөлийн цар хүрээ улам нэмэгдэж, гарал үүсэл тодорхойгүй бүтээгдэхүүн ихэнх хувийг эзлэх болсон нь улсад татвар төлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Үүнээс үүдэлтэйгээр ашигт малтмалын нөөцийн бүртгэл, хөдөлгөөний тооцоо будлиантаж, байгаль орчны нөхөн сэргээлт хийгддэггүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй болж давхар давхар хүндрэл бэрхшээл үүсч байдаг байна. Үүнд:

- Хайлуур жоншны салбарын үйлдвэрлэлийн өнөөгийн байдалд ямар дүгнэлт хийж байна вэ? экспортыг орлох, төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байгаа юу?
- Энэ салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорт болон улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх ямар бодлого, үйл ажиллагаа явуулжбайгаа болоод үр дүн нь ямар байна вэ?.
- Хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, татварын тэгш, шударга зарчмыг хэрэгжүүлэх, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих талаар ямар бодлого хэрэгжүүлж байна вэ?
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах; хайлуур жоншны бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгодог болох замаар татварын бааз суурийг өргөтгөх, АМНАТ-ийг бүрэн төвлөрүүлдэг болох; Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг хийж жишиг үнэ тогтоох аргачлал, журмыг боловсронгуй болгох шаардлага байна уу, энэ чиглэлээр хийгдэж байгаа зүйл байна уу?.

- Салбарын яамны зүгээс Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоод, төрийн бус байгууллагатай хэрхэн хамтран ажиллаж байна вэ?

Асуулгын хариуг хуулийн дагуу бэлтгэж ирүүлсний дараа УИХ-ын чуулганд сонсох талаар хамтран ажиллах болно.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Д. Тэрбишдагва

У. Чулаан

ЧУЛААН

Д.ТЭРБИШДАГВА

